



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 2/128

Цагаантолгой

Бүх нийтээр мод тарих өдрийг

зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, Засгийн газрын 2021оны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 350 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн “Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах” тухай А/380 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын нутаг дэвсгэрт ” Бүх нийтээр мод тарих “ арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсугай.

2.Бүх нийтээр мод тарих өдрийг байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг хамруулж тарьсан модоо арчилж хамгаалах ажлыг төлөвлөж, зохион байгуулж, хариуцан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга / А.Одхүү /-д үүрэг болгосугай.

3.Тарьц, суулгац худалдан авах ажилд шаардагдах хөрөнгийг төлөвлөлтийн дагуу зарцуулахыг Санхүүгийн албаны дарга /Г.Ууганцэцэг/-т зөвшөөрсүгэй.

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Ч.Тогтоолбаяр
Хянасан: Ч.Амгалан
Хувь: 2
Огноо: 2022.10.04